

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Өвөрхангай аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг 03 сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж, “Аймгийн зарим газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай”, “Аймгийн зарим газар нутгийг тусгай хамгаалалтанд авах тухай”, “Бат-өлзий сумын зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтаас чөлөөлүүлэх тухай”, “Төсөвт зохицуулалт хийх тухай” асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа хийж, тус хуралдаанаар Арвайхээр суманд шинэ суурьшлийн бүсийн амины орон сууцны төслийн нэгж байгуулах тухай, Хужирт рашаан шавар болон цэвэрлэх байгууламжийн талаар цаашид авах арга хэмжээний тухай, Цахим тоглоомын газрын үйл ажиллагаанд хяналт тавих тухай, Уул уурхайн нөхөн сэргээлтийн байдалд шалгалт хийсэн дүнгийн тухай, Иргэний хяналтын баг ажиллах журам батлах тухай, Нийтийн сонсгол зохион байгуулах тов зарлах тухай, Алдарт эхийн одонд тодорхойлох, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, ИТХ-ын бараа ажил үйлчилгээний бусад зардал зарцуулах эрхийн тухай, Төсөвт өөрчлөлт оруулах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж, 14 тогтоол гаргаж, нэг асуудалд тэмдэглэлээр үүрэг өгөв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дүгээр сарын 14-ний өдрийн 42 дугаар зарлигаар Монгол Цэргийн өдрийг тохиолдуудан Төрийн дээд одон, медалиар шагнагдсан 10 иргэний шагналыг гардууллаа.

Аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс 2019 оныг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх” жил болгон зарлаж, зорилтот жилийн төлөвлөгөөний саналыг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн, төлөвлөгөөг батлан гаргав. Мөн сумдад Сумдын ГХУСАЗСЗөвлөлд холбогдох зөвлөмжийг хүргүүлэв.

Улс төрийн хэлмэгдэгч Оргийн Чулууны нөхөх олговрын 500,000 төгрөгийг түүний төрсөн хүүхэд болох Хужирт сумын иргэн Чулуун овогтой Дулмаахүүд, хэлмэгдэгч Батнасангийн Насан-очирын нөхөх олговрын 1000,000 төгрөгийг түүний төрсөн хүүхэд болох Хархорин сумын иргэн Дашдондог овогтой Гунгаа нарт тус тус гардууллаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлөөс аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн удирдлагууд, хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журмуудын талаар мэдээлэл өгч, арга зүйгээр хангав.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар аймгийн газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай, Бат-Өлзий сумын зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтаас чөлөөлүүлэх санал, “Жендэрийн дэд хөтөлбөр” батлах, сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, баг, гудамж, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг шалгаруулах болзолт уралдааны удирдамж батлах, Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн амины орон сууцны хорооллын төслийн нэгж

байгуулах, газар эзэмшүүлэх түр журам батлах, Зүүнбаян-Улаан сумын Соёлын төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг нэрэмжит болгох тухай, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний дүн, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэн шийдвэрлэв.

Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд баригдах 182 айлын тохилог хаус хорооллын танилцуулгыг аймгийн Засаг дарга Г.Ганболд Арвайхээр сумын иргэдэд танилцуулсан бөгөөд амины орон сууцны хороололд 5 төрлийн загвартай хаус баригдахаар төлөвлөгдсөн юм. Эдгээр хаус барилгын талбайн хэмжээ нь 63.8 м.кв-аас 101.8м.кв, өмчлөлийн газрын хэмжээ нь 260.0м.кв-аас 675.5м.кв талбайтай. Тус хаус хорооллын инженерийн шугам сүлжээ, дулаан, цахилгаан, автозам, явган хүний зам зэргийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэнэ.

“Арван аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Арвайхээр хотод шинээр баригдах дулааны станцын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний танилцуулгаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, аймгийн удирдлагууд, төрийн албан хаагчид, дулаан хангамжийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, иргэдийн төлөөлөл оролцов.

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Дархан аварга Д.Цэрэнтогтохын нэрэмжит спортын ордны дэргэд олон улсын стандартад нийцсэн бэлтгэлийн заалыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орууллаа.

Түүх, соёлын хөдлөх өвийн улсын үзлэг, тооллогын ажлын хэсэг Эрдэнэзуу музей, аймгийн музей, 18 сумын Орон нутаг судлах танхим болон Шанхын баруун хүрээ, Төвхөн хийдийн соёлын өв, үзмэр эд өлгийн зүйлийг удирдамжийн дагуу тоолох бөгөөд 14 сумын орон нутаг судлах танхимыг сумын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагчдын хамт тооллого хийгээд байна.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний түүхт 98 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын нэрэмжит Марш тактикийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, “Арвайхээр цэргийн хүрээний Зэвсэгт хүчний анги, салбар, Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын дунд зохион байгуулагдсан уг тэмцээнд Зэвсэгт хүчний 256, 113 дугаар ангиуд, Онцгой байдлын газар, Хархорин сумын Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Тагнуулын хэлтсийн багууд оролцов.

Ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил төлөвшүүлэх, монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилгоор Аймгийн Засаг даргын ивээл дор цэрэг-спортын “Дөл-2019” тэмцээнийг зохион байгуулж, 9 багийн 117 тамирчин оролцов.

Аймгийн хэмжээгээр 16087 малчин өрхөд 2.3 сая хээлтэгч мал тоологдож, одоогийн байдлаар нийт хээлтэгч малын 16,6 хувь буюу 394,6 мянган мал төллөж, гарсан төлийн 98.9 хувь нь буюу 390.8 мянган төл бойжиж байна. Мөн нийт хээлтэгчийн 0.3 хувь буюу 7.4 мянган мал хээл хаясан байна. Энэ өвөл, хаврын байдлаар 11 сумын 1060.0 мянган га-д бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно тархаад байна. Үүнээс Бүрд, Баян-Өндөр, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл сумдад тархалт нилээн их болж, малчдын хаваржилтын асуудалд сөргөөр нөлөөлж байна.

Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд энэ сард нийт 65 санал гомдол ирсэн бөгөөд 50 гомдол, 14 санал, 1 иргэн мэдээлэл авахаар хандсан байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 6172 иргэн үйлчлүүлсэн.

ХОЁР. Эдийн засаг, төсөв, санхүү:

Аймгийн улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилт авч сарчилсан хуваарийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлсэн.

Тусгай зориулалтын шилжүүлэгээр ерөнхий боловсролын сургууль 2.7 тэрбум, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 1.1 тэрбум, хүүхдийн хөдөлмөр хамгааллын үйлчилгээний тусгай шилжүүлэг 29.7 сая, эрүүл мэндийн тусгай шилжүүлэг 591.6 сая, газрын, харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг 46.1 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 450.1 сая төгрөг санхүүжилт авч хуваарийн дагуу аймаг болон сумдын төсвийн байгууллагуудад шилжүүлэв.

Аймгийн хэмжээнд 5 хуулийн этгээд нэмж бүртгүүлж, 1299 хуулийн этгээд, 129 салбар газар 604 төрийн бус болон төсөвт байгууллага, 28189 иргэний бүртгэлтэй нийт 30218 бүртгэлтэй татвар төлөгчийн бааз суурьтай үйл ажиллагаа явуулж байна.

НӨАТатвар 256, онцгой албан татвар 2, бусад 1201 татвар төлөгчийн сар, улирал, жилийн тайланг хүлээн авч, холбогдох програмууд дээр татварын ногдол, тайлангийн уялдаа, тайлангийн хөрвөлт, бусад ногдол программд хөрвөж буй байдалд хяналт тавьж ажиллав. 2019 оны жилийн эцсийн татварын тайлангуудын нэгтгэл боловсруулалтын шатандаа явагдаж байна.

Улсын төсөвт 75.6 сая, аймгийн төсөвт 151.3 сая, сумын төсөвт 135.4 сая төгрөг, нийт 362.3 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах иргэний материалыг 29 байцаагч, хураагч нар хүлээн авч 1728 татвар төлөгч иргэний 718.5 сая төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр материал бүрдүүлэн өгсөн байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн платформын Хур системээс иргэний үнэмлэхийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, төрсний гэрчилгээний лавлагаа, нийгмийн даатгалын лавлагаа 204 татвар төлөгчид олгосон.

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг Арвайхээр суманд явагдаж аймгийн хэмжээнд 352 татвар төлөгчөөс 19.2 сая төгрөгийг авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар, агаарын бохирдлын төлбөрт 1.201.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллаж байна.

Аймгийн төрийн сангаас 98 мэдээлэл, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газраас 37 байгууллагын мянган төгрөг, Арвайхээр сумын ЗДТГ-аас тендерийн 46 мэдээллийн 280,000.0 мянган төгрөгийн мэдээллийг хүлээн авч программд шивж орууллаа.

Жилийн эцсийн тайланд эрсдэл тооцож борлуулалтын зөрлөлтэй тайлагнасан 89 иргэн, ААНБ-ын тайланг засварлуулахаар ТТХТасагт хүргүүлсэн. НӨАТ-ын босго хүрсэн 4 ААНБ-ыг бүртгэх талаар ТТХТ-т шилжүүлсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангуудын төлөвлөгөө 1779.4 сая төгрөг, гүйцэтгэл 1957.89 сая төгрөг төвлөрүүлж, сангийн төлөвлөгөө 110 хувиар биелсэн байна.

Энэ сард шинээр 12 ажил олгогчийн 91 даатгуулагч шинээр албан журмын даатгалд хамрагдсан байна.

Нийт 808 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 538.5 сая төгрөгний тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 327 даатгуулагчдад 29.7 сая төгрөг, ЖА-343 даатгуулагчдад 347.1 сая төгрөг, Оршуулга 83 даатгуулагчдад 83.0 сая төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмж 55 даатгуулагчдад 78.7 сая төгрөгийг тус тус олгосон байна.

ЭХМК-ын 4 удаагийн хурлаар нийт 271 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцсэн ба үүнээс шинээр 46, цуцалсан 17, шилжиж ирсэн 0, шилжсэн 1, нас барсан 0, сунгасан 207 хүний хөдөлгөөний мэдээллийн баазад оруулсан.

Арвайхээр болон бусад сумдын 3 дүгээр сарын тэтгэврийг хугацаанд нь олгож, өндөр насны 186, тахир дутуугийн 89, тэжээгчээ алдсаны 13 нийт 288 иргэний тэтгэврийг шинээр тогтоогоод байна.

Шимтгэл төлсөн төлөөгүй тодорхойлолт 73, цалингийн лавлагаа 57, сайн дурын лавлагаа 5, нөхөн тооцохын лавлагаа 5 лавлагаа нийт 140 иргэнд архивын лавлагаа авсан байна.

Хэрэглэгчийг үнэлэх үнэлгээний төхөөрөмжөөр энэ оны 3-р сард 15 байцаагч 942 иргэд, даатгуулагчаас үнэлгээ авсан байна. Уг үнэлгээгээр онц үнэлгээ өгсөн 179 даатгуулагч, сайн үнэлгээ өгсөн 11, дунд үнэлгээ өгсөн 4 муу үнэлгээ өгсөн 4 даатгуулагч байна. Үнэлгээ ирүүлээгүй 738 даатгуулагч байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

Сангийн сайдын удирдамжаар Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 3 төсөвт байгууллагын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Цагдаагийн газартай хамтран 6 сумын сум хөгжүүлэх сангийн 2017, 2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалтыг явууллаа.

Нийгмийн халамжийн сангийн 2017, 2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд асаргааны болон байнгын асаргааны тэтгэмж илүү олгосон 11 иргэний 1624,2 мянган төгрөг, цалинтай ээжийн тэтгэмжийг илүү олгосон 52 иргэний 10600,0 мянган төгрөг, илүү тайлагнасан өглөг 12746,0 мянган төгрөг, нийт 24970,2 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, шалгалтн явцад 28 иргэнээр 5354,2 мянган төгрөгийг нийгмийн халамжийн санд төлүүлж, 32 иргэний 6700,0 мянган төгрөгийн зөрчлийг төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 12936,0 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлын тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2017, 2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 2 иргэнд ажилгүйдлийн шимтгэл 345,1 мянган төгрөгийг дутуу олгосон зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага өгсөн

Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хархорин, Бүрд, Есөнзүйл, Баян-Өндөр сумдын сум хөгжүүлэх сангийн 2017, 2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 967563,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 303627,5 мянган төгрөгийг төлүүлэх улсын ахлах байцаагчийн акт, 182487,1 мянган төгрөгийг төлүүлэх илэрсэн зөрчлийг арилгуулах улсын байцаагчийн 19 заалт бүхий албан шаардлага өгч, хуурамч баримтаар зээл авсан гэх 8000,0 мянган төгрөгийн зээлийг цагдаагийн газарт шилжүүлж шалгаж байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5353,5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 21 заалт бүхий зөвлөмж өглөө.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 208, боловсон хүчний 16, захирамжийн төсөлд шийдвэр гаргах зөвшөөрлийн хуудсаар үйлчилгээ үзүүлж, баталгаажигдсан шийдвэрийг бүртгэлжүүлэн санд байршууллаа. Аймгийн Засаг даргаас 02 дугаар

сарын 25-ны өдрийн байдлаар нийт 224 шийдвэр батлагдан гарсан бөгөөд тус шийдвэрүүдийг аймгийн www.uvurkhangai.mn цахим сайтад байршуулан иргэдэд мэдээллийг шуурхай авах боломжийг ханган ажиллаж байна.

Аймгийн Ахмадын хорооноос “Ахмадын хорооны аймгийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд уг зөвлөгөөнд оролцож Ахмад настны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар нийт 60 гаруй оролцогчдод сургалт, мэдээлэл хийлээ.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын “Аян зохион байгуулах тухай” А/124 дүгээр захирамжаар төлөвлөгөө, удирдамжийг гарган батлуулж, сум, байгууллагуудад чиглэл хүргүүлэн ажиллав. Энэхүү аяны хүрээнд төрийн байгууллагууд хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, хэрэглэгч, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, аюулгүй, ухаалаг бараа бүтээгдэхүүн үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, хэрэглэгчдэд сургалт мэдээлэл хийх ажлуудыг зохион байгуулав.

Аймгийн архивын тасагт байгууллага, иргэдээс 406 өргөдөл хүлээн авч 169 лавлагаа, 658 хуулбар, 75 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 198 хадгаламжийн нэгжийн 21522 хуудас, 13855 заалт, 111865 хүний нэр, 19418 байгууллагын нэр 23322 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 173 хадгаламжийн нэгжийн 23204 хуудас баримтыг PDF файл үүсгэн цахим холболтыг хийн, 163 хадгаламжийн нэгжийн 13108 хуудас баримтыг скайнердаж, 235 хадгаламжийн нэгжийн 21002 хуудас баримтыг Photoshop программд оруулсан байна.

Хадгаламжийн сан дахь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийж, сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг төрийн архивт дадлагажуулах сургалтад хамрагдуулсан.

ЦАГДААГИЙН ГАЗАР

Аймгийн Цагдаагийн газарт 2019 оны эхний 3 сард 1124 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 629 буюу +2.2 дахин өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 278, зөрчлийн шинжтэй 846 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгаж байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 231 буюу 83,0 хувийг 5 хоногт, 36 буюу 12,9 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 694 буюу 82.0 хувийг 3 хоногт, 117 буюу 13,8 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Аймгийн хэмжээнд 03 дугаар сард 82 холбогдогчтой, 664.3 сая төгрөгийн хохиролтой, 194 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 32 хэргээр буюу +19.7 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 16.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -11.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр нь авч үзвэл хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 49 бүртгэгдэж 18-аар буюу -26.8 хувиар буурсан, хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдэж 3-аар буюу -27.2 хувиар, авто тээврийн хэрэгсэл ашитлалтын журмын эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 11-ээр буюу -64.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдэж 24-өөр буюу +3.0 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 84 бүртгэгдэж 30-өөр буюу +55.5 хувиар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж 12-оор буюу +7.0 дахин тус тус өсч, албан тушаалын гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 72.6 хувийн эзэлж байна.

Аймгийн хэмжээнд өмчлөх эрхийн эсрэг 84 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах төрлийн 32, малын хулгайлах гэмт хэрэг 25, тээврийн хэрэгсэл хулгайлах 7, дээрэмдэх 2, залилах 9 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 18 буюу +55.5 хувиар өссөн байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг цонх хагалах, хөших, цонхоор орох, гэр, орон сууцны хаалга, цоожийг нь эвдэж орох, малын хулгайн гэмт хэрэг нь иргэдийн хараа хяналт сонор, сэрэмж сул, малаа байнга хариулага маллагаагүй орхидог, цахимаар иргэдийг хууран мэхэлж, итгэл эвдэх байдлыг ашиглан үйлдэгдэж байна.

Нийт бүртгэгдсэн 194 гэмт хэргээс 49 буюу 25.3 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

Захиргааны зөрчил өмнөх оноос 2474 буюу 53.0 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

Нийт бүртгэгдсэн 7139 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 502 зөрчил байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламж, гэмтлийн тасгийн тусламж үйлчилгээнд үнэлгээ хийж, БОЭТ-ийн удирдлагын баг, яаралтай тусламжийн тасгийн болон өрхийн эрүүл мэндийн эмч, мэргэжилтнүүдтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлээ тодорхойлон, зөвлөмж хүргүүллээ.

"Яаралтай тусламжийн цогц менежмент" сургалтыг Түргэн тусламжийн амилуулах нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын 142 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, түргэн тусламжийн жолооч нар хамрагдсан.

"Тэжээхүй ухаан" төрийн бус байгууллагатай хамтран "Судас оношилгоо" "Уламжлалт барьж оношлох, засах аргачлал" "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгийн уламжлалт анагаах ухааны 32 эмчийг хамрууллаа.

Олныг хамарсан осол гэмтлийн үеийн үзүүлэх сургуулилтыг Онцгой байдлын газар, Замын цагдаагийн тасаг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран зохион зохион байгуулж, 300 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.

БОЭТ-тэй хамтран Сүрьеэгийн өвчлөлийг эрт илрүүлэх илрүүлэг үзлэгийг Арвайхээр сумын 3 өрхийн эрүүл мэндийн төв дээр зохион байгуулсан. Эрсдэлд бүлгийн 817 хүн үзлэг, шинжилгээнд хамрагдахаас 736 буюу 90 хувийг хамруулж, 27 хүнээс цэрний шинжилгээ авч шинжилэхэд олон эмэнд дасалтай сүрьеэ-1, уушигны эрхтэний бус сүрьеэгийн 1 тохиолдол тус тус батлагдаж, 1 сүрьеэгийн сэжигтэй тохиолдол илэрсэн, онош тодруулах ажлыг зохион байгуулж байна. Энэ үеэр сүрьеэ эдгэрдэг өвчин, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажиллалаа.

"Хариуцлага-Хүндлэл-Дуурайлал" эрчүүдийн өдөрлөгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, мэдээлэл сурталчилгаанд хамруулах, тэдний эрүүл

мэндийг дэмжих зорилгоор "Эрүүл мэндийн өртөөг" зохион байгуулсан. Үүнд: Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны чиглэлээр эрүүл мэндийн өртөө ажлуулах, хэвлэл мэдээллийн сувгаар сурталчлах, Биеийн жингийн индексийг тодорхойлж, хувь хүнд тохирсон дасгал хөдөлгөөний зөвлөгөө өгөх, В. С вирусийн илрүүлэх шинжилгээнд хамруулах зэрэг үйл ажиллагаануудыг амжилттай зохион байгууллаа. үйл ажиллагаанд нийт 160 гаруй эрчүүдийг хамрууллаа.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын удирдамж хөтөлбөр боловсруулж, Арвайхээр сумын 23 сайн дурын идэвхтнийг бэлтгэж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон.

Осол гэмтлийг бууруулах аяны хүрээнд зохион байгуулсан ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан гар зураг, видео шторкийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг хэлтсийн хурлаар хэлэлцүүлэн оноог нэгтгэж дүгнэн, шилдгээр шалгарсан 6 бүтээлийн эздийг шагнаж урамшуулан, шалгарсан бүтээлүүдийг байгууллагын цахим хуудсаар нийт 2000 гаруй иргэдэд сурталчилав.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Зүүнбаян-Улаан, Хархорин сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгууллаа. Дээрх ажлын хүрээнд Боловсрол, соёлын талаарх хууль, тогтоомж, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр боловсрол, соёлын байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн зэрэгтэй танилцаж, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Шалгалт зохион байгуулах тухай" А/42 дугаар тушаалаар монгол хэл бичгийн шалгалтын босго оноог 400 байхаар тогтоож, монгол хэл бичгийн шалгалтыг 3 дугаар сарын 23, 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Эхний удаагийн монгол хэл бичгийн шалгалтыг 3 дугаар сарын 23-ны өдөр Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль дээр зохион байгууллаа. Тус шалгалтад 790 шалгуулагч орохоор бүртгүүлснээс 769 шалгуулагч шалгалтад хамрагдсан.

Мөн "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 6.12 дахь заалтын боловсролын чанарын үнэлгээний судалгааг 2019 оны 3 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд 19 сумын 26 сургуульд зохион байгууллаа. Тус судалгаанд Лаборатори Мэргэд, Хархорин сумын ерөнхий боловсролын Орхон сургууль, Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагчид математик, монгол хэл, хөгжим, хүн орчин хичээлээр, 10 дугаар ангийн сурагчид математик, монгол хэл, газарзүй, биологийн хичээлээр хамрагдсан бол бүх ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчид математик, монгол хэл, физик, англи хэлний хичээлээр хамрагдлаа.

Түүх соёлын дурсгалт зүйлийн хөдлөх өвийн Улсын үзлэг тооллогыг зохион байгуулж байна. Үүнд: Аймгийн музейд 98 хувь, 18 сумын Орон нутаг судлах танхимуудын тооллого 97 хувьтай програмд оруулалт 70%-тай явагдаж байна.

Аймгийн Цэргийн дуу дуулаачдын IY уралдааныг зохион байгууллаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Соёлын үйлдвэрлэл" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Хайрхандулаан сум санаачлан аймгийн уралдаан болгон 4 дэх удаагаа зохион байгууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зөвлөлийн болон Өвөрхангай аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2019 оны төлөвлөгөөнд оруулах саналыг нэгтгэн зөвлөлийн хуралд танилцууллаа. Энэ чиглэлээр сургуулиудын нийгмийн ажилтнуудад чиглэл өгч ажиллалаа.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Бүхнийг хүүхдийн төлөө” уриан дор Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний автобусыг 3 дугаар сарыг дуустал хүүхэд болон иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх ажлыг хэрэгжүүлж 6000 насанд хүрэгчид, 14000 хүүхэд нийт 20000 хүнд салбарын талаарх хууль тогтоомж, ажил үйлчилгээ, арга хэмжээний талаарх танилцуулга мэдээллийг хүргэж, брошур, гарын авлага, сонин тарааж ажилласан. Энэхүү үйл ажиллагааг Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага, Арвайхээр тохижилт үйлчилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна.

Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 7-8-р ангийн 80 гаруй сурагчдийг хамруулан “Үе тэнгийн дээрэлхэл ба нөхөрлөл”, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн “Дотуур байрны” 9-12 ангийн охид, хөвгүүдэд “Улаан шугам ба охид хөвгүүд” сургалтыг нийт 6 удаа орж, сэтгэл зүйн боловсрол олгосон. “Охидын сэтгэл зүйн онцлог ба таатай орчин” хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулав зохион

Ардын болон хүүхдийн дууны “Дуулах өв-2019” аймгийн наадмыг зохион байгуулж, 14 сумын 50 гаруй сурагчид оролцож, 3 насны ангилалд 2 төрлөөр өрсөлдөн шилдгүүдээ тодруулж, шалгарсан сурагчдад улсын уралдаанд оролцох эрхийн бичиг олголоо.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2 хүүхэд, 1 иргэнийг “Түр хамгаалах” байранд байрлуулж, сэтгэл зүйн зөвлөгөөг өгч, оношилгоо хийж, эрүүл мэндийн тусламж үйчилгээнд холбон зуучилж үйлчилсэн. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын зөвлөгөө өгөх өрөөгөөр дамжуулан гэр бүл цуцлалттай холбоотой 2 иргэн, “хүүхэд хүмүүжүүлэх арга” 2 иргэн, хууль зүйн зөвлөгөө 2 иргэн, гэр бүлийн харилцааны зөрчлөөр 3 иргэн, 5 хүүхэд, зан үйлийн өөрчлөлтөөр 3 хүүхэд, харилцааны зөрчил 6 асуудлаар хандаж, 16 хүүхэд, 9 иргэн нийт 25 үйлчлүүлэгчдэд сэтгэлзүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.

Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 6-12 ангийн 702 хүүхдээс зан үйлийн тулгамдсан асуудал судалгааг 5 үзүүлэлтээр /сэтгэл зүйн хямрал, зан үйл хурцдал, хэт хөдөлгөөнтөх, харилцаа, үе тэнгийн дарамт/ авч ажиллалаа. Судалгаагаар эрсдэл өндөр 93, эрсдэл дунд 133, хэвийн 476 сурагч байна гэсэн дүгнэлт гарлаа.

“Явуулын сэтгэл зүйн зөвлөгөө өгөх булан” ажиллуулан Ерөнхий боловсролын 1-р сургуульд 8 хүүхэд, 2-р сургуульд 3 хүүхэд, 4-р сургуульд 3 хүүхэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Мөн цагдаагийн “Түр хамгаалах байранд” саатуулагдаж буй Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнд сэтгэл зүйн ганцаарсан уулзалт хийн, оношлогоо хийсэн.

“НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ 2019-ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭВ НЭГДЛИЙН ХАНА” арга хэмжээг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, залуучуудын хөгжлийн төв, Насан туршийн боловсролын төв, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, LECTOR center сургалтын төв хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээг охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэглэж буй бүхий л хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэхээр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 100 охид, мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төвийн 39 албан хаагчид оролцлоо.

Аймгийн Хүүхдийн ордны сургалтын танхимд төлбөртэй болон төлбөргүй 14 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 1319 иргэнийг хамруулан, 290.000 төгрөгийн орлого бүрдүүлж ажиллалаа. Ордны дэргэдэх 20 дугуйлангаар дамжуулан нийт 367 хүүхдэд хөгжлийн үйлчилгээг хүргэлээ.

“Хариуцлага-Хүндлэл-Дуурайлал” Арвайхээр сумын аавуудын анхдугаар өдөрлөгт төрийн болон төрийн бус байгууллага, хувиараа бизнес эрхэлдэг аавуудын төлөөлөл зэрэг нийт 175 аавууд /гэр бүлийн хамт/ оролцлоо.

Хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд залуусын оролцоог нэмэгдүүлж олон нийтийн хандлагад нөлөөлөх, орон нутагт ирээдүйн утга учиртай оролцоог нэмэгдүүлэх, улмаар хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцэх иргэдийн оролцоог бэхжүүлэх зорилгоор “Нэг тэрбумаараа тэмцье” нөлөөллийн арга хэмжээг ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн ахлах ангийн 100 охидыг хамруулан Арвайхээр сумын ЗДТГазар, НТБТөв, Лектор центр сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгууллаа.

Сурагчдын уран илтгэх хэл ярианы чадвар, өөртөө итгэх итгэл, харилцааны соёлыг нэмэгдүүлэх мөн нийгэмд өөрийн дуу хоолойгоо хүргэх оюунлаг иргэдийг бий болгох зорилгоор “Оюуны давалгаа-IV” уран илтгэлийн аймгийн тэмцээнийг Лидер сурагч академитай хамтран зохион байгууллаа. Тэмцээнд нийт 32 сурагч оролцож өөрийн мэдлэг, чадвараараа өрсөлдөж шилдэгүүд шалгарлаа.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Хүүхдийн спортын VI их наадмын сагсан бөмбөг, мөн наадмын хүрээнд Боловсролын тэргүүний ажилтан, Биеийн тамир спортын тэргүүний ажилтан, багш, дасгалжуулагч Р.Дэмбэрэл агсны нэрэмжит волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, бадминтоны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 700 гаруй тамирчин хүүхдүүд хамрагдлаа.

Аймгийн Шагайн золголт харвааг Арвайхээр суманд зохион байгууллаа. Тэмцээнд 20 багийн 180 харваачид оролцож Нарийнтээл, Есөнзүйл, Гучин-Ус сумын багууд эхний байруудыг эзэллээ.

Пауэрлифтингийн 2019 оны 8 дахь удаагийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдлаа. Тэмцээнд 9 сум, 5 байгууллага, 14 багийн 80 тамирчин 4 ангиллын 17 жинд өрсөлдлөө. Өсвөр ангилалд хөвгүүдийн 4 жин, охидын 2 жин нийт 6 жинд 35 тамирчин, залуучуудын ангилалд 2 жинд 13 тамирчин, мастер ангилалд нэг жинд 4 тамирчин, насанд хүрэгчдийн ангилалд 28 тамирчин оролцож жин тус бүрийн аваргууд тодорлоо.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 32 дугаар Цогц хөтөлбөр, 2009 оны 05 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх, “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл аж төрөх ёс”-ыг сурталчлах аяны хүрээнд чөлөөт цагаараа биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, эрүүл мэнддээ анхаарах, спортын арга хэмжээнд оролцуулах зорилгоор аймгийн удирдлагууд болон Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудын дунд спортын 4 төрлийн тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 6 багийн 60 хүн оролцлоо.

“Алтан аргай” цомын тэмцээн Спортын ордонд зохион байгуулагдлаа. Тэмцээнд хот, хөдөөгийн нийт 26 багийн 260 харваач оролцсоноос багийн харвааны 1-р байранд МУ-ын мэргэн Б.Ганбат ахлагчтай Өлзийт сумын баг, 2-р байранд аймгийн гоц мэргэн Б.Мөнх-Эрдэнэ ахлагчтай БТСГ-ын баг, 3-р байранд аймгийн мэргэн Ядамсүрэн ахлагчтай Хужирт сумын баг (буу), тэмцээний цуваа харвааны 1-р байрыг Өмнөговь аймгийн харьяат МУ-ын мэргэн Е.Одгэрэл, 2-р байрыг Хужирт сумын харьяат Эрдэнэцэцэг (буу), 3-р байрыг Уянга сумын харьяат Аймгийн гоц мэргэн Б.Ганзориг нар эзэллээ.

Монголын хүүхдийн спортын VI их наадмын цанын шигшээ тэмцээн "Скай Резорт" цанын баазад 03 дугаар сарны 01-03 нд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 14 байгууллагын 143 тамирчин 4 насны ангиллаар өрсөлдлөө. Б.Батдорж дасгалжуулагчтай 10 тамирчин оролцож, эрэгтэй буухиа төрөлд хүрэл медаль, багаараа 5 байрт шалгарлаа.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

Энэ оны 3 сарын байдлаар 265 шинэ ажлын байр бий болж хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөг 117 иргэнд өгч, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс 171 ажлын байрны захиалга хүлээн авч 144 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид хамрагдах 7 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж, ажил хайгчаар бүртгэн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлсэн.

Улаанбаатар хотын "Шинэ хөгжлийн түлхүүр" төрийн бус байгууллагатай хамтран Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, "Мэргэд" лаборатор сургуулиудын 9 дүгээр ангийн нийт 260 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг зохион байгуулсан. Мөн дээрхи байгууллагатай хамтран 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр "Нэг өрх- Нэг ажлын байр" хөтөлбөрт хамрагдсан өрхийн хөдөлмөрийн насны, ажил идэвхтэй хайж буй иргэдэд "Ажил хайгч иргэдийг чадавхижуулах" бүлгийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хөтөлбөрт хамрагдсан өрхийн ажил хайгч 61 иргэн хамрагдсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 2016 онд хамрагдан зээлийн эргэн төлөлтөө бүрэн барагдуулаагүй 27 иргэний асуудлыг Иргэний хэргийн шүүхэд шилжүүлж, эвлэрлийн гэрээ байгуулан ажилласан. Мөн эвлэрлийн гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан хугацаанд эргэн төлөлтөө барагдуулаагүй 9 иргэний асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлээ. 2017 онд төсөл хөтөлбөрт хамрагдан санхүүгийн дэмжлэг авч эргэн төлөлтөө хугацаандаа барагдуулаагүй 15 иргэнд хугацаатай албан мэдэгдэл хүргүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 13, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 9, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 нийт 23 иргэний үйл ажиллагаанд хяналт хийж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж 150 иргэнийг бүртгэсэн. Үүнээс "Дэлгэрэх бүтээмж" ТББ-тай хамтран 60 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Солонгос хэлний түвшин тогтоох 15 дахь удаагийн шалгалтын бүртгэлийн ажлыг зохион байгуулж 151 иргэнийг бүртгэсэн. Эдгээр иргэдийн 34 нь буюу 22,5 хувь нь эмэгтэйчүүд байна.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019" сарын аяны бэлтгэл ажлыг хангаж аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн хурлаар сарын аяны удирдамж, төлөвлөгөө, нээлтийн арга хэмжээний хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулсан.

Улс болон орон нутгийн төсвөөс халамжийн тэтгэвэрт 529.4 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 242.3 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид

150.8 сая төгрөг, ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээнд 192.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 68.9 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 70.9 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 173.4 сая төгрөг, банкны шимтгэл, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 4.5 сая төгрөг, алдар цолтон ахмад настнуудын тэтгэмжид 10.0 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 1350.4 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 470.0 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 610.3 сая төгрөг нийт давхардсан тоогоор 35448 иргэнд 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд шинээр болон дахин хамрагдахыг хүссэн 49, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 4, нийт 53 өргөдлийг хүлээн авсан. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 82 өрхөөс авсан судалгаа болон шинээр төрсөн 212 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх босго оноог хангасан тухай тодорхойлолтыг 11 иргэнд олгосон.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй магадлан итгэмжлэлийн эрхээ сунгуулах 4, шинээр магадлан итгэмжлэлийн эрх авах 4 нийт 8 төрийн бус байгууллагад “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ын талаар танилцуулж, дүгнэлт гаргаж ХХҮЕГ-т хүргүүлсэн.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүрээнд 1664 өрхийн 8630 иргэнд 102912.0 сая төгрөгийн цахим эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 1 удаа хуралдаж 4 хүүхдийн асуудлыг хэлэлцсэн. Хурлаар 2 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 2 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоосон. Хурлаар хэлэлцсэн 4 хүүхдийн 2 нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Малчдыг сургалт мэдээллээр хангах, мэдлэгжүүлэх зорилгоор Мерси-кор Монгол олон улсын байгууллага, аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран “Чадавхжсан малчин” сургалт хэлэлцүүлгийг Хужирт, Тарагт, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан сумдад зохион байгууллаа.

Мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлого зохицуулалтын газар болон Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэн ажиллаж байна. 03 дугаар сарын 20-ны байдлаар нийт хээлтэгч малын 4.5 хувь буюу 107.7 мянган мал төллөж гарсан төлийн 98.9 хувь нь буюу 106.1 мянган төл бойжиж байна. Мөн нийт хээлтэгчийн 0.3 хувь буюу 7.4 мянган мал хээл хаясан байна. Оны эхний нийт малын 0.1 хувь буюу 6.7 мянган мал зүй бусаар хорогдсноос тэмээ 3, адуу 138, үхэр 225, хонь 2834, ямаа 3545 байна.

Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагаа зохиох ажил үүрэг хуваарийн дагуу хэвийн явагдаж байгаа ба авто тээврийн хэрэгсэл дамжин өнгөрөх цэгээр дайран өнгөрч буй мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, болон дайвар бүтээгдэхүүний тээвэрлэлт, аюулгүй байдал, эрүүл мэнд, ариун цэвэр гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж зөрчил гарсан тохиолдолд им тамга, гарал үүсэл, орон нутгийнх нь кодтой тулгаж үзэх шаардлагатай нөхцөлд орон нутгийнх

нь эрх бүхий албан тушаалтантай холбогдож гарал үүслийг бататгах, ариутгал халдваргүйтгэлийн ажил хийгдэж байна. 2019 оны эхний 3 сарын байдлаар мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгийн постоор тээврийн хэрэгсэл 235, адуу 122, үхэр 8, хонь 480, ямаа 130, бүгд 740 мал, арьс 94523 ширхэг, шир 10680 ширхэг, нэхий 6500 ширхэг, мах 507460 тн, ноос 27500 тн, аарц 440 кг, өрмөн тос 80 кг, өвс 371000 кг, хивэг 35000 кг, бог малын толгой 10000 ширхэг тус тус дамжин өнгөрсөн болно.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа "ӨВ-ЭКО МИЙТ", "ДЭЛХИЙН ХҮНС" махны үйлдвэрт зөвлөх үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, махнаас дээж авч, шинжилгүүлэхээр хүргүүлж, ариутгал, халдваргүйтгэлийн гэрээ хийсэн.

Сумдын мал амьтдын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины 2020 оны захиалгыг тархварзүйг судалгааны үндсэн дээр боловсруулж сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, судалгааг нэгтгэж байна.

Азийн Хөгжлийн Банкны нэмэлт санхүүжилттэй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн баг, аймгийн Засаг даргын төслийн ажилтан, аймгийн Засаг даргын дэргэдэх ХХААГазартай хамтран Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад төслийн танилцуулга уулзалтыг Арвайхээр суманд зохион байгууллаа. Уг танилцуулга уулзалтад Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан сумдын 100 гаран жижиг дунд бизнес эрхлэгчид оролцлоо.

Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэр эрхэлж буй үйлдвэр, цех, өрхийн үйлдвэрүүдийн судалгааг гаргахад 545 өрхийн болон жижиг дунд үйлдвэрт 1700 гаруй иргэн ажиллаж буй судалгаа гарсан байна.

Арвайхээр сумын "Өв Санаа" ХХК-д "Европын Холбоо"-ны санхүүгийн болон Европын Сэргээн босголт хөгжлийн банкны дэмжлэг тусламжтайгаар ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн нээлтийн арга хэмжээ амжилттай боллоо. Мөн ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн сургалтад "Өв Санаа" ХХК-ны удирдлагууд болон ХХААГазрын холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа.

Газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Япон улсын Хоккайдо мужийн Такикава хотоос зөвлөх багш нар аймагт ажиллалаа. Арвайхээр суманд бөөрөнхий сонгиныг үрслэгээр тарих технологи болон хүлэмжинд өргөст хэмх, лооль, чинжүү тариалах технологийн сургалтыг хамтран зохион байгууллаа. Мөн зөвлөх багш нар Арвайхээрийн загвар аж ахуйтай танилцаж сонгины үр суулгагчийг өгч арга зүйн зөвлөгөө өгөв.

Өвөрхангай аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймгийн Үсчин, гоо засалчдын холбоотой тус тус хамтран аймгийн "Гоо сайхны ертөнц" үсчин, гоо засалч, хумс засалчдын сургалт, мэргэжил сурталчилах ур чадварын уралдааныг 2019 оны 03-р сарын 20-22 өдрүүдэд зохион байгууллаа.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт 14, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт 1-г хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн 16 иргэн, аж ахуйн нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож нэгж талбарын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлэн улсын бүртгэлд бүртгэж газрын мэдээллийн санд орууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/167 дугаар захирамжаар 12 өрхийн нэр бүхий 31 иргэний өмчлөх эрхийг шилжүүлсэн, А/166 дугаар захирамжаар 22 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн газрын хэмжээнд өөрчлөлт оруулан мэдээллийн нэгдсэн санд оруулсан, А/168 дүгээр захирамжаар “Монгол Улсын ирэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлөх хүсэлт гаргасан 34 иргэнд 1.7 га газрыг тус тус өмчлүүлсэн.

Аймгийн Спортын ордоны “Б” заалны барилгын гүйцэтгэлийн төсвийг хянаж, тендер зарласан ажлаас хийгдээгүй, нэмж хийсэн ажлын төсвийг тусад нь гаргуулав.

Аймгийн Засаг даргын дэргэдэх МШУТөвд Арвайхээр сумын 455 дугаар байрны оршин суугчдын ирүүлсэн гомдлын дагуу газар дээр нь үзлэг хийж хөрсний усны нэвчилтийг зогсоход шаардлагатай хөрөнгийн тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагуудад хандах талаар оршин суугчдад зөвлөмж өгөв.

“Өв пост” ХХК-ийн захиалгаар баригдсан 57 айлын орон сууцны “А” блокийн барилгыг ашиглалтад авах комисст ажиллав.

Аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 145/ШТ2018/00043 дугаар тогтоолын дагуу иргэн М.Мөнхчулууны нэхэмжлэлтэй “Их Богд Оргил” ХХК-д холбогдох иргэний хэрэгт газрын даргын тушаалаар томилогдож, холбогдогчоос орон сууцны барилгын батлагдсан зургийг авахаар удаа дараа шаардаад авч чадахгүй, хамгийн сүүлд авахаар хэлэхэд холбогдогч байгууллагын захирал нь шүүхээс хэрэгсэхгүй болгосон захирамж ирсэн гээд авчирч өгөхгүй байсан тул тооцоо хийж шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй байгаа талаар шүүхэд албан тоот хүргүүлэв.

ХОХБТХэлтсийн мэргэжилтэн, зургийн байгууллагын төлөөлөлтэй хамт Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр, Сант, Баянгол сумдын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийх барилгуудын ажлын тоо хэмжээ гаргах ажлаар явж ашиглагчийн саналыг авч, хэмжилт хийв.

Тарагт сумын Соёлын төвийн барилгад нэмэлт ажлын гэрээ хийхээр ирүүлсэн төсвийг хянаж, экспертизээр хянагдсан төсөв, тендерээр зарласан ажлын тоо хэмжээнд тусгагдаад хийгдээгүй шаланд хивсэнцэр наах ажлын төсвийг түүн гаргаж, ажлын зурагнаас үзвэрийн заалны шалны тоо хэмжээг тооцон зөрүүг хасч тооцохоор санал оруулав.

2019 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус газрын лабораторийн лаборантуудад 3 дугаарын сарын 25-27-ний өдрүүдэд БМСШЛабораторид бетон, дүүргэгч материалын шинжилгээнд чадавхижуулах, цементийн шинжилгээнд дадлагажуулах болон мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж хамтран ажиллах талаар БХТөвд албан тоот хүргүүлэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Тохижилт-ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн хүрээнд хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай аймгуудын “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах нь” сэдэвт хангайн бүсийн зөвлөгөөнийг 2019 оны 03 дугаар сарын 04-05-ны өдөр зохион байгуулж 5 аймгийн БОАЖГ-уудын мэргэжилтнүүд, Арвайхээр сумын холбогдох байгууллагуудын төлөөлөл нийт 60 хүн хамрагдлаа.

02 дугаар сарын 28-аас 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд Бүрд, Есөнзүйл суманд халиун буганд, 03 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Зүүнбаян-Улаан сумын нутаг, Уянга сумын Жаргалантын нуруунд байрших янгир ямаанд биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, уг ажлыг холбогдох сумдын

БОХУБайцаагч байгаль хамгаалагч нартай хамтран гүйцэтгэж, Ан амьтныг хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа нөхөрлөл хамт олныг шагнаж урамшууллаа.

“Дэлхийн усны өдөр”-ийг “Цэвэр ус- тэгш хүртээмж” уриан дор тэмдэглэж, уг ажлын хүрээнд усыг хайрлан хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлэх, байгаль экологийн боловсрол олгох, усыг ухаалаг, зөв зохистой хэрэглэх зан үйлийг хэвшүүлэх зорилгоор Онги Таац голын сав газрын захиргаа, Ус, цаг уур орчны шинжилгээний албатай хамтран ЕБСургуулийн бага, дунд ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа.

Мөн Мэргэд сургуулийн “Цэнхэр сувд” клубын сурагчидад “Бидний ус хаанаас ирдэг вэ?” аялалыг зохион байгуулж, “Онги ус суваг” ОНӨААТҮГазрын үйл ажиллагаатай танилцуулан, усны үнэ цэнэ болон зүй зохистой хэрэглэх талаар чөлөөт ярилцлага хийж цаашид хэрхэн энгийн үйлдлээр усаа хайрлан хамгаалах талаар мэдээлэл хийж, уг клубын хүүхдүүдэд ногоон паспортыг олголоо.

Дэлхийн усны өдрийн хүрээнд уламжлал болгон зохион байгуулагддаг байгаль орчны салбарын байгууллагуудын аварга шалгаруулах спортын 3 төрөлт тэмцээнд 8 багийн 80 гаруй тамирчид оролцлоо.

Тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын газраас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд зарим газар нутгийг аймгийн тусгай хамгаалалт, хэрэгцээнд авах тухай, Бат-Өлзий сумын зарим нутаг дэвсгэрийг улсын тусгай хэрэгцээнээс гаргах санал уламжлах тухай асуудлуудыг өргөн барьсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/02 дугаар тогтоолоор аймгийн газар нутгийн байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах, ховор, ховордсон ургамал, амьтан, усны нөөц, газрын өвөрмөц тогтоц, түүхийн дурсгал бүхий газар түүний орчныг хамгаалах зорилгоор шинэчлэн 14 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 10 газрын 871167,8 га талбайг аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг батлуулж, хурлын 2019 оны 10/01 дугаар тогтоолоор Нарийнтээл сумын нутаг дэвсгэрт орших 34.6 га газрыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд, Бат-Өлзий сумын нутагт орших Улсын хамгаалалттай 3090 га газрыг улсын тусгай хэрэгцээнээс хэсэгчлэн гаргах санал уламжлах тухай тогтоол гарч, тогтоолыг холбогдох газарт уламжилсан.

“Чехийн People in need Mongolia” төслийн багтай хамтран гаднах орчны агаарын бохирдлыг хэмжих IQAir багажийг ЕБ-ын 2 дугаар сургууль, Арвайхээр сумын ЗДТГ-ын гадна суурилуулж дотор орчны бохирдол хэмжих 1 багажийг БОЭТ-ийн цахим бүртгэлийн хажууд суурилууллаа.

Сум дундын Ойн анги орчны бүсэд 35 га талбай тусгаарлаж 1 аж ахуй нэгж, 3 ойн нөхөрлөл, ОХБЦГазрын ойн сангийн зөвшөөрөгдсөн бүсэд 27 га талбай тусгаарлалт хийж 4 аж ахуй нэгж, 2 ойн нөхөрлөл, 3 иргэдийн бүлгээр ойн цэвэрлэгээний ажлыг 2019 оны 02-р сарын 25-наас 2019 оны 03-р сарын 25 хүртэлх хугацаанд гүйцэтгүүлж, тусгаарлалт хийсэн 62 га талбайгаас хэрэглээний мод 1232 шоо метр, түлээний мод 594 шоо метр мод бэлтгэж орон нутгийн төсөвт 17589.0 мянган төгрөг төвлөрүүлээд байна.

Бат-Өлзий сумын ИТХурал, ЗДТГазар, Сум дундын Ойн анги, Цагдаагийн хэсэг хамтарч “Бидний амьдрах орчин” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж тус суманд ойгоос мод бэлтгэдэг, мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 300 орчим иргэд оролцлоо. Хэлэлцүүлгээр Бат-Өлзий суманд Ойн тухай хууль тогтоомж зөрчигдөж гэмт хэрэг ихсэж байгаа шалтгаан нөхцөлийг тодруулж түүнээс урьдчилан сэргийлэх, Ойн тухай хууль, Ойгоос мод бэлтгэх журам, уламжлалт аргаар мод бэлтгэхэд зөвшөөрөл олгож байгаа байдал, ой ашиглалтын өнөөгийн байдал,

тулгамдсан асуудлын чиглэлээр мэдээлэл хийж иргэдээс тусгайлан бэлтгэсэн санал асуулгын хуудсаар санал авч нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Агаарын дундаж температур -1.2 -4.6 градус хүйтэн, нийт нутгаар ихэнх хугацаанд шөнөдөө -5 -16 градус хүйтэн, өдөртөө 3 -8 градус дулаан байсан. Агаарын дундаж температур олон жилийн дунджаас 0.7-5.6 градус дулаан, Богд сум орчимоор -0,7 градус хүйтэн байлаа. Нийт нутгаар ихэнх хугацаанд салхи 4-9 м/сек, Баян-Өндөр, Арвайхээр, Төгрөг, Богд, Баянгол, Сант сумдын нутгаар зарим хугацаанд салхи 15-18 м/сек хүрч салхилсан байна. Хархорин, Богд, Баруунбаян-Улаан сумдын нутгаар 5,1мм-7,5мм тунадас, бусад сумдын нутгаар 0,7 мм -4,8 мм тунадас орсон байна.

Бат-Өлзий сумын ус судлалын харуул орчим ёроолдоо хүртэл хөлдсөн, мөсний зузаан 150 см бол Хархорин сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджийн орчим, мөсний зузаан 71 см, усан зах үүссэн байна.

Хөгшин Орхон голын усны түвшин Хархорин сумын ус судлалын харуул орчим мөсний зузаан 20 см, мөс байрандаа хайлж байна. Уянга сумын ус судлалын харуул орчим битүү мөсөн бүрхүүлтэй, мөсний зузаан 86 см буюу өмнөх арав хоногоос 16 см нэмэгдсэн, Арвайхээр сумын ус судлалын харуул орчим ёроолдоо хүртэл хөлдсөн, мөсний зузаан 43 см байна. Нарийнтээл сумын ус судлалын харуул орчим мөсний зузаан 72 см, мөсөн дээгүүр ус урссаж байна. Өлзийт сумын ус судлалын харуул орчим ёроолдоо хүртэл хөлдсөн, мөсний зузаан 39 см байна.

Голуудад мөсөн дээгүүр ус урсаж, мөс хэврэгшиж байгаа тул ард иргэдийг цаг хожих, зам товчлох зэргээр мөсөн дээгүүр явах, авто тээвэр хийхээс татгалзаж, мөс цөмрөх аюулаас болгоомжлохыг онцгойлон анхааруулж байна.

Арвайхээр сумын агаарын чанарын үзүүлэлтээр хүхэрлэг хийн /SO₂/ агууламжийн дундаж 12 мкг/м³, хамгийн их агууламж 85 мкг/м³, азотын давхар ислийн /NO₂/ агууламжийн дундаж 30 мкг/м³ хамгийн их 136 мкг/м³ байгаа нь АЧС/агаарын чанарын стандарт/ дахь хүлцэх агууламжтай харьцуулахад давсан бохирдолгүй байна.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Аймгийн Засаг даргын "Хөрөнгө шийдвэрлэх тухай" а/83 дугаар захирамж гарч хөрөнгийн дуудлага худалдаа 2019 оны 03 сарын 18-ны өдөр Арвайхээр суманд нээлттэйгээр зохион байгуулагдаж Хужирт сумын ЗДТГазар, аймгийн ШШГГазар, Бүрд сумын ЭМТөв, Сант сумын ЭМТөвийн нийт 4 авто машин дуудагдахаас Бүрд сумын ЭМТөвийн УАЗ 31512 маркийн 23-85ӨВР дугаартай авто машин 3200000 төгрөгөөр зарагдаж аймгийн хөрөнгө худалдсаны орлого дансанд мөнгийг төвлөрүүлсэн. 2018 оны жилийн эцсийн статистик мэдээг 195 орон нутгийн өмчит байгууллагаас нэгтгэн авч ТӨБЗГазарт хүргүүлсэн

Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дараах ажлуудын тендер сонгон шалгаруулалтууд зарлагдаад байна. Үүнд: Арвайхээр сумын 320 хүүхдийн сургууль, Хархорин сумын 320 хүүхдийн сургууль, Арвайхээр сумын Залуучуудын усан спортын цогцолбор, Баруунбаян-Улаан сумын сургуулийн дотуур байр, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, Нарийнтээл сумын 240 хүүхдийн сургууль, Уянга сумын сургуулийн дотуур байр, Баянгол сумын Соёлын төвийн барилга, Хужирт 75 ортой цэцэрлэгийн барилга, Хархорин сумын 75 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын тендерүүдийг зарлаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилга ажил, Цагдаагийн газрын барилга Инженерийн хийцтэй гүний худаг, Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Арвайхээр суманд кино театр байгуулах, Гудамж талбайн гэрэлтүүлэг, засвар шинэчлэлийн ажил, Нийтийн тээврийн парк шинэчлэл, Өөрөө буулгагч самсвол, мод шилжүүлэн суулгах машин, байгууллагын захиалгаар хэрэгжих Мэргэжлийн хяналтын газарт шатах тослах материал нийлүүлэх, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүнсний бүтээгдэхүүн, шатах тослах материал нийлүүлэх зэрэг тендерүүдийг үнэлэж гүйцэтгэгчийг шалгарууллаа.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

Монгол улсын Засгийн газрын 189-р тогтоолоор батлагдсан “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” тогтоолыг үндэслэн сурталчилан таниулах, хэрэгжүүлэх зорилгоор аж ахуй нэгж, албан байгууллага бүрийг “Хүн бүр даавуун уут хэрэглэж хэвшье” уриатайгаар аймгийн аж ахуй нэгж, албан байгууллага бүрийг хамруулахаар энэхүү давалгаа (challenge) аянг эхлүүлээ. Аяны хүрээнд бид “Ноос ирээдүй” ХХК-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд үндэсний үйлдвэрлэл, орон нутгийн бизнес эрхлэгчдээ дэмжих зорилготой.

Стандартчилал, *техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн* тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу 3 сарын байдлаар 31 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийснээс 3 аж ахуйн нэгжийн 6 бүтээгдэхүүн, 21 иргэн, 4 аж ахуйн нэгжийн 29 үйлчилгээний газар нийт 36 дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож ажиллалаа.

Засгийн газрын 2018 оны 291-р тогтоолын хавсралтаар батлагдсан тохирлын баталгаанд заавал хамрагдах бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад орсон 16 нэр төрлийн үйлчилгээний газраас худалдааны газар 26, нийтийн хоол 3, зочид буудал 1 тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийсэн.

Худалдаа, үйлчилгээний тооцоо, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа цахилгаан, хүнд, даралт, эзэлхүүн хэмжлийн 4 төрлөөр 79 ширхэг хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийж, 661200 төгрөгний орлоготой ажиллаж, эзэлхүүн хэмжлийн төрлөөр 11 ширхэг түгээгүүр, хүндийн хэмжлийн төрлөөр 33 ширхэг жин, цахилгаан хэмжлийн төрлөөр 24 ширхэг тоолуур, даралт хэмжлийн төрлөөр 11 ширхэг манометр хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулаа.

СУМДЫН МЭДЭЭЛЭЛ

Нарийнтээл суманд 62 залуучуудын дунд “Нутаг усаараа бахархъя” сэдэвт сургалтыг зохион байгуулж, залуучууд төрөлх нутгаасаа төрөн гарсан алдартанууд болон түүхийн дурсгалт газруудыг танилцуулав. Мөн “Хүүхэд хэрэглэгч аян”-ы хүрээнд сумын НТБ-ын нэгж, ЗДТГ, ЭМТөвтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэргийн насны залуучуудын дунд “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Хэрэглэгчийн эрхийн өдрийн талаарх танилцуулга”, бүтээгдэхүүний шошго тэмдэглэгээг уншиж таних, хүнсний аюулгүй байдал зэрэг сэдвээр 3 удаагын сургалтыг зохион байгууллаа.

Арвайхээр суманд хүүхэд багачуудыг урлагийн амьдралд ойртуулах, ардын хөгжимтэй дуулах урлагт сургах, өвөг дээдэс, ард түмний дундаас уламжлагдан ирсэн ардын дууны өв сангаас суралцуулах, хүүхдийн дууны урын санг баяжуулах, мартагдсан дууг сэргээн өвлүүлэх, ирээдүйн авьяаслаг дуучдыг тодруулах зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг ардын болон хүүхдийн

дуу дуулаачдын “Дуулах өв-2019” улсын уралдааны сумын хэмжээний шалгаруулалтыг “Хүүхдийн ордон”-д зохион байгууллаа.

Есөнзүйл сумаас улсын чанартай автозам орох зам болон номын өргөөний ойр орчны нийт 24 га газрын хогийг сумын Засаг даргын Тамгын газрын ажилчдын хүчээр цэвэрлэж, 3 тн гаруй хогийг төв хогийн цэгт буулгасан байна.